



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 1/67

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол цзэн тай ХХК-ийн “Вен жөү” зочид буудлын 18/334, Эвээр засах ХХК-ийн “Вашингтон” зочид буудлын 18/221, Ансен ХХК-ийн “Ану-Үжин” зочид буудлын 18/318, МБММ ХХК-ийн “Уянга” дэн буудлын 18/295, Цэлгэр орд констракшн ХХК-ийн “Ланс” дэн буудлын 18/322, Лайткристал

Интернэшил ХХК-ийн "Кристал" дэн буудлын 18/320 , Чанцало ХХК-ийн "Дөлгөөхөн" дэн буудлын 18/119 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн Ч.Энх-Отгон /-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялалжуулчилалын  
газрын даргын 2019 оны 08  
сарын 14 өдрийн А/67 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284025 СБТ 48936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.08.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монголия Тоёоко Инн ХХК	5939666	Тоёоко Инн	БГД-ийн, 2-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 9Д байр
2	Монгол цээн тай ХХК	2668289	Вен жөү	БЗД-ийн, 14-р хороо, Намъянжүгийн гудамж 19 тоот
3	Централ хотел Азия ХХК	6314104	Централ	БГД-ийн, 1-р хороо, Хатанбаатар Магсаржавын гудамж 89 тоот
4	Эвээр засах ХХК	5631858	Вашингтон	БЗД-ийн, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-41 тоот
5	Ансен ХХК	2662159	Ану-Үжин	БЗД-ийн, 3-р хороо, Англи элчин сайдын яамны баруун талд

-ооОо-

Нийслэлийн Аялалжуулчлалын  
газрын даргын 2019 сны 08  
сарын 14 өдрийн А/67 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.08.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	МБММ ХХК	2600072	Уянга	БГД-ийн, 5-р хороо, 10-р хороолол 11/2 тоот өргөтгөл
2	Шидэт аялгуу ХХК	5248853	Цолмон	СХД-ийн, 28-р хороо, Сансар 1/6 тоот
3	Цэлгэр орд констракшн ХХК	5831776	Ланс	БГД-ийн, 4-р хороо, Замчдын гудамж 7/1 тоот
4	Лайткристал интернэшнл ХХК	5165318	Кристал	СХД-ийн, 31-р хороо, Хайрханы 2-59 тоот
5	Чанцало ХХК	2858657	Дөлгөөхөн	БГД-ийн, 10-р хороо, Зүүннаран 0-1-8 тоот
6	Омхэ ХХК	5277728	Саруулхан	БЗД-ийн, 5-р хороо, Монелийн 1-14 тоот

-000oo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 08  
сарын 14 өдрийн A/67 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 8936 1116263502

АМРАЛТЫН ГАЗРЫН УЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2019.08.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монтэн бридж ХХК	5856558	Мон тэнгэр лодж	НД-ийн, 6-р хороо, Баянцагаан давааны урд

-000oo-